

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-24

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлт /Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/ 6-18

2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл 6-24

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 4 дүгээр сарын 14-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 35 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Номинчимэг, Л.Соронзонболд, С.Эрдэнэболд;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Э.Батшугар, Ж.Баярмаа, Б.Дэлгэрсайхан,
Б.Пүрэвдорж, Г.Уянгахишиг;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Б.Тулга;
Тасалсан: Х.Баттулга.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлт
/Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Ганбат, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Алтанхуяг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай

хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 7

Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 7

Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 8

Бүгд: 15

46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15

53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Нарантуяа-Нара, Д.Ганбат нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах хүрээнд үе тэнгийн дээрэлхэлтийн шалтгаан, нөхцөл, илэрлийн хэлбэр, хор уршгийг тодорхойлон үнэлж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 7

Бүгд: 15

53.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, дэд ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ж.Баярмаа, Б.Баярбаатар, Д.Ганбат, М.Нарантуяа-Нара, Г.Уянгахишиг нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 00 минут үргэлжилж, 27 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 11 цаг 35 минут

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдааны ирц 51.9 хувьтайгаар бүрдсэн байна. Ирцэд бүртгүүлсэн гишүүд Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дашдондогийн Ганбат, Мөнхтөрийн Нарантуяа, Гонгорын Дамдинням, Салдангийн Одонтуяа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар гэсэн гишүүдийн ирцтэйгээр бүрэлдсэн байна аа.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 2 асуудал хэлэлцэхээр байгаа.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлт. Энэ Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай ийм дүгнэлт байж байгаа.

Хоёр дахь нь Байнгын хорооны тогтоолын төсөл яригдахаар байгаа.

Ийм л 2 асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал хэлэх гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл ингээд хэлэлцэх асуудлаа баталлаа.

Нэгдүгээр асуудалдаа орьё. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал хийнэ. Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

О.Батнайрамдал: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсгийн Улсын дээд шүүх, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн Улсын дээд шүүхийн Тамгын газар гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг тогтоолгохоор иргэн С.Номынбаясгалангийн гаргасан мэдээлэл.

Монгол Улсын Дээд шүүхийн хүсэлтээр ҮХЦ маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн. Уг маргаанд Улсын Их Хурлыг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр миний бие Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 159 дүгээр захирамжаар томилогдон ажиллалаа.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 сарын 27-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар уг маргааныг хянан шийдвэрлэсэн бөгөөд миний бие 2025 оны 5 сарын 2-ны өдрийн Улсын Их Хурлын 035568 дугаар албан бичгээр хариу тайлбарыг хүргүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Баясгалан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Гангабаатар, Мөнхсайхан, Болдбаатар, Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэй хуралдаж Монгол Улсын үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон дараах дү дүгнэлтийг гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг дүгнэх хэсгийг та бүхэнд товч танилцуулъя.

Нэгдүгээрт Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт Улсын дээд шүүх 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн Тамгын газарт гэсэн нь Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалтад шүүхэд гомдол гаргах шударга шүүхээр шүүлгэх эрхтэй.

47 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

48 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт шүүхийн зохион байгуулалт үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

5 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 5 дахь заалтад хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх гэж заасанд нийцэхгүй байна.

2 дугаарт Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт Улсын дээд шүүх 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн Тамгын газарт гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалтад шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй гэсэн заасныг зөрчөөгүй байна.

Гуравдугаарт Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт Улсын Дээд шүүх 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэгт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн Тамгын газарт гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй гэж дүгнэсэн байна аа.

Байнгын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Батнайрамдал гишүүнд баярлалаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Тусдаа үг хэлнэ. Ганбат гишүүнээр тасалъя. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би энэ Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын дүгнэлтийг бид хүлээж авах нь зүйтэй гэж бодож байгаа. Бас Улсын Дээд Шүүхийн Үндсэн хуулиар олгогдсон үндсэн чиг үүрэгт хамаарахгүй асуудлуудыг өгсөн гэж хувьдаа бас боддог. Яах вэ зүгээр хуулийн этгээдийн бүртгэл талаас Улс төрийн намын бүртгэл Улсын дээд шүүх дээр явж байгаа. Цаашдаа зүгээр уг асуудлыг илүү СЕХ байдаг юм уу тэр тал дээр нь өгөөд яг Улсын дээд шүүх бол энэ хууль хэрэглээний нэгдмэл практик тогтоодог. Хяналтын журмаар, эсвэл бас хуулиар олгогдсон тохиолдолд бас анхан болон давж заалдах шатын журмаар хэрэг маргаанаа шийдвэрлээд явах л ийм функцээ хэрэгжүүлэх нь зүйтэй. Ер нь зүгээр Мэргэжлийн нэгдсэн холбооны энэ хуулийн үзэл баримтлалыг ч гэсэн эргэж нэг хармаар юм байгаа юм. Хуулийн этгээдүүд ер нь мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах гэхээсээ илүүтэй ХАҮТ-даа л нэгддэг олон улсын жишиг гадаад улсын туршлага байгаа. Тэгэхгүй ингээд эдийн засгийн холбоо байгуулаад тодорхой хэмжээний зах зээл дээр манипуляц болон картель үүсгэх ер нь үгсэн хуйвалдах ийм тохиолдлууд байдаг. Ийм тохиолдлууд бас гарах эрсдэлүүд байгаа.

Яах вэ зүгээр холбоог байгуулахдаа тухайн салбарын боловсон хүчнийг чадавхжуулах нийтлэг эрх ашгаа гэдэг болоод цаанаа бас ийм зүйлүүд байдаг. Жишээ нь Нефть импортлог импортын холбоо гээд үндсэндээ бараг цөөн тооны ААН байгууллагууд Засгийн газарт шахалт үзүүлэх байдалтай ингээд явж байгаа, банкнуудын холбоо ч байдаг юм уу. Уг асуудлууд уг нь зүгээр ХАҮТ дахь банкны холбоон дээрээ нэгдэх банкны танхим дээрээ эсвэл ХАҮТ дахь нефть импортлогчдын холбоо танхим дээрээ л нэгдэх ёстой. Ингэж байж бас энэ асуудлууд зөв зохистой явна аа.

Харин мэргэжлийн холбооны асуудлыг бол нэгдсэн хуулиар явах бас хэр үр дүнтэй байх уу, үгүй юу сайн мэдэхгүй байна. Яах вэ зүгээр ийм сонгодог жишээ бол манай Хуульчдын холбоо байхгүй юу. Яг тухайлан хуультай. Илүү бас яг амьд гэх юм уу даа энэ бодгаль ийм этгээдүүд үүсгэн байгуулна гэсэн үг эмч нар ч гэдэг юм уу. Тусдаа эмч нарын суурь харилцааг зохицуулсан тийм хууль бас явж байгаа юм байна лээ гэх зэргээрээ тухайн салбар дээр үүсэж байгаа мэргэжлийн холбоонууд аль болох нийтийн эрх ашгийг нэлээн хөндөж байгаа асуудал бол хуультай байдаг. Бусдууд нь бол ТББ-ын хуулийн хэмжээндээ зохицуулагдаж болно.

Тэгэхдээ яг нэгдсэн холбоо гэдгийг юу гэх вэ? Нэг хэсэг 1, 2 хүмүүс нэгдчихээд ингэж явж байгааг ойлгох уу эсвэл тухайн салбар дахь яг албан ёсны бүртгэлд хамрагдсан этгээдийн харьцангуй олонх буюу 40-өөс 50 хувийг нэгтгэж байж цаашдаа мэргэжлийн холбоо болгох уу үгүй юу гэдэг концепцоосоо эхлээд зөв болгохгүй энэ бол энэ бол зүгээр цөөн тооны этгээдүүд өөрсдийнхөө мэргэжлийн холбоо гээд Улсын дээд шүүх дээр бүртгэл гаргуулж аваад тухайн салбарыг төлөөлөөд төртэй тэр салбарын эрх нийтлэг эрх ашиг ярих гээд байгаа байхгүй юу. Төлөөлж чадахгүй. Тэгэхээр энийг зүгээр ямар ч байсан би бас протоколд үлдээгээд ер нь зүгээр цаашдаа энэ нэг.

Д.Цогтбаатар: Минутаа нэмж авах уу? Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Минут дуусахаас өмнө ямар ч гэсэн хүлээгээд авъя гэдэг дээр байа. Тэгээд яг манай Байнгын хороо бас ТББХ-той л ярих байх уг асуудлаар. Тэгэхээр ер нь эдийн засаг уу ярих нь зөв. Төрийн ч олон чиг үүргүүдийг бас хувийн хэвшил мэргэжлийн холбоонд шилжүүлье гээд байгаа боловч бас яг хэнд шилжүүлэх нь тодорхой бус байгаа. Тийм учраас энэ асуудлыг илүү их зөв зохицуулъя л гэж байгаа юм. Тэгээд яг энэ Мэргэжлийн нэгдсэн холбооны энэ хуулийн концепц нь ер нь зөв үү үгүй юу гэдэг дээр ч гэсэн Улсын Их Хурал өөрөө нөгөө хяналт шалгалтынхаа байдаг юм уу хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хүрээндээ бас нэг дүгнээд яаж сайжруулж болох вэ гэдгээ нэг гаргаад авъя. Тэгээд энэ Улсын дээд шүүхэд бас хаа хамаагүй ийм улс төрийн шинжтэй энэ ер нь бас улс төрийн шинжтэй болно. Ийм зүйлүүдийг бас бүртгүүлэх ч гэдэг юм уу ийм зүйл өгч байгаа нь буруу байх гэж бодож байна. Тэгээд Цэцийн энэ дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй л гэж бас саналаа хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Асуулт биш үг болчихлоо. Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

О.Батнайрамдал: Сайнзориг гишүүн үг хэллээ. Гэхдээ бас асуулттай бас холбож болохоор л байна л даа. Энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт дээр Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхэлснээс

хойш нэг яг хэрэгжилт дээр нэг ганц жишээ л гарсан юм байна. 2024 оны 1 сарын 9-нд Улсын дээд шүүх дээр энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд Хуурай замын тээврийн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо гэдэг хуулийн этгээд бүртгүүлэхээр хандсан юм байна аа. Бүртгүүлэхээр хандаад удаагүй, дахиад яг энэ холбоон дээр дахиад нэг гишүүн 8 ААН-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс энэ хуулийн этгээд нь бид нарыг ингээд төлөөлөхгүй гэсэн маргааныг бас ингэж гаргасан юм байна л даа.

Тэгэхээр ер нь ганцхан явсан жишээ нь одоо хүртэл ийм маргаан дагуулсан. Хоорондоо мэргэжлийн холбоодоо хүлээн зөвшөөрөхгүй байнга маргаан дагуулсан ийм асуудал бас үүсэж байгаа юм байна аа. Тэгэхээр энэ хууль хэрэгжсэнээс хойш ганц гарсан жишээ нь ингээд маргаан дагуулсан талаар энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд бас ингэж дурдагдсан байгаа юм.

Тэгэхээр тантай зарчмын хувьд бас санал нэг байна. Тэгэхээр энэ хуулийг ер нь үзэл баримтлалын хүрээнд бас дахин авч үзэх нь магадгүй зөв байх. Улс төрийн намын бүртгэл бол Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дээр орсон байдаг юм байна лээ. Гэхдээ энэ дээр бас улс төрийн намын бүртгэлээс энд нэгдсэн холбоодын бүртгэлийг ялгаатай зарчмыг нь бол Үндсэн хуулийн энэ цэцийн дүгнэлт дээрээ бас тусгаж өгсөн байна л даа. Яг энэ дээр яг тайлбарласнаар бол улс төрийн үзэл бодлоо чөлөөтэй эвлэлдэн нэгдэх үндсэн эрхийг хангах Үндсэн хуульд заасан төрийн эрх ард түмний мэдэлд байх зарчим, иргэн, улс төрийн нам байгуулж эсвэл намд элсэх нэгдэх замаар төрийн удирдахад оролцох эрхийг баталгааг хангах Улсын дээд шүүх оролцох ийм агуулгын хувь шал 2 өөр зүйл учраас гэсэн тайлбарыг бас энэ дээр тусгаж өгсөн юм байна лээ.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ерөнхийдөө Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байна аа. Гэхдээ ер нь бид нар чинь юу вэ өнөөдөр чинь 10 цагаас ХЗБХ хуралдана гээд ингээд зар тараасан. Бараг л цаг 30 минут хүлээж байж эхэлж байх шив дээ. Тэгэхээр энэ МАН буюу энэ олонх энэ ирцээ бүрдүүлж бай. Ирцийг энэ Одонтуяа гишүүн, Алтанхуяг гишүүн, Тэмүүжин гишүүн бид 4 л бүрдүүлээд суугаад байна шүү дээ. Сайнзориг гишүүн орж ирж байна. Нэг иймэрхүү л байдалтай байна шүү нөхдүүд минь. Тэгээд Улсын Их Хурлын нөгөө нэг хариуцлагын асуудал чинь энүүгээр л илрээд байгаа шүү дээ Ёс зүйтэй байх тийм энд энэ бүх зүйлүүд чинь энэ дээр анхаармаар байгаа юм энэ МАН энэ олонх. Тэгээд хоорондоо л хэрүүлээ хийгээд байх юм гэх мэтчилний. Манай юм чинь бүгд л эсрэгээрээ болчихсон байна шүү. Төмөр замыг нууцаар барина гэнэ, нүүрсээ нууцаар зарна гэнэ. Учир нь олдохгүй олдохгүй юм ярьдаг болчихсон. Тэгээд тэрийгээ байх ёстой юм шиг. Тэрнээсээ баахан мөнгө хулгайлчихсан тэрүүгээрээ баахан троллуудыг хөлсөлчихсөн тэгээд л хүн амьтан руу дайруулаад л зөв юм шиг болгоод л ингээд явж байдаг ийм юм байна. Энэ дээр анхаарахгүй бол энэ Улсын Их Хурлын нэр хүнд энэ бүх юм чинь унаж байна шүү. Мэргэжлийн холбоод их чухал. Тэгээд манайд бүх юм эсрэгээрээ байх юм л даа. Одоо нэг мэргэжлийн холбоо чинь ийм жижигхэн улс оронд чинь нэг л баймаар юм. Тэгэхэд чинь карим газар 2, 3 байна уу? Мэргэжлийн холбоодууд. Тэр нь хоорондоо зөрөлдөөд л нэг иймэрхүү. Энийг үзсэн үү, харсан уу? Манай хуульдаа байдаг юм уу юундаа байдаг юм? Энийг бас засаж залруулах хэрэгтэй юм шиг байна. Мэргэжлийн холбоод маань жинхэнэ ёсоороо ажиллаад эхэлбэл энэ бүх зөвшөөрөл өгөх, энэ төр засаг, энэ ажилд оролцох энэ юмнууд чинь багасах ёстой шүү дээ. Бусад улс орон тэр чигт л явж байна тийм байна. Гэтэл манайд эсрэгээрээ 1, 2 гуравхан хүн нийлээд мэргэжлийн холбоо байгуулчихдаг.

Тэрийгээ тэгээд бусдадаа хаалттай оруулж ирэхгүй, хаасан боосон маягтай иймэрхүү маягтай явдаг.

Тэгээд хоорондоо баахан маргалдаад л ингэж явдаг тэгээд мэдээж хэрэг тэрийг шүүх дээр очиж шийдүүлэх нь зөв л байх л даа. Тийм шүүх дээр энэ шийдэж өгч байх ёстой байх. Улс төрийн нам байна. Улс төрийн намын бүртгэл бол тэр шүүх дээр байх нь буруу юм шиг байна лээ. Тэр СЕХ дээрээ байх ёстой байх. Тэр асуудлыг нь бол мэдээж хэрэг шүүх нэгэнт татвар төлөгчдийн мөнгийг аваад хэрэглэж байгаа ийм улс төрийн нам дөхөж байгаа үед бол улс төрийн нам тэр асуудлаа бас шүүхэд мэдүүлээд шийдүүлдэг байх нь зөв шүү дээ.

Д.Цогтбаатар: Тодруулах уу? Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Ганбат гишүүний асуултад хариулъя. Иргэд ТББ байгуулах хуулиараа эрхтэй. ТББ-аас аваад үзэх юм бол хэдэн мянган төрийн бус байгууллагууд байгаа юм. Өнөөдрийн бид нарын ярьж байгаа хууль бол мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль. Нэг ёсондоо энэ мэргэжлийн холбоод өөрсдөө хоорондоо зөвшилцөөд нэгдсэн холбоо байгуулж болно. Энэ нэгдсэн холбоогоо одоогийн мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулиар бол Улсын дээд шүүх дээр яг улс төрийн нам шиг бүртгэнэ гэсэн агуулгыг оруулж өгсөн юм байна.

Энэ өөрөө 2024 онд батлагдсан хууль байгаа. Гэхдээ Үндсэн хуулийн цэцээс энийг бүртгэх нь Үндсэн хууль зөрчиж байна гэсэн дүгнэлтийг гаргаад өнөөдөр бид нар хэлэлцэж байна л даа. Тэгэхээр улс төрийн намыг бүртгэх таны 2 дахь асуулт улс төрийн намын бүртгэл нь ондоо, СЕХ ч юм уу тэ ондоо хуулийн этгээдээр бүртгэх зарчим ярьж байна л даа. Тэгэхээр энийг өөрчлөх ч юм уу эрх нь та бүхэнд бас бүгдээрэнд нь бидэнд бүхэн нээлттэй байгаа. Гэхдээ ҮХЦ дээр бас энэ оруулсан тайлбартаа бол агуулгын хувьд ингэж бас туссан байгаа юм. Хүний эрхийг ноцтой зөрчсөн, ялгаварлан гадуурхсан, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал үндэсний эв нэгдлийг ноцтой аюул учруулахуйц хууль бус үйл ажиллагаа явуулах улс төрийн намыг бүртгэлээс татгалзах ийм хууль бус ажиллагаа явуулж буй намыг тараах улс төрийн эрх барих дээд байгууллагыг нийтээрээ чөлөөтэй сонгох эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг оролцоотой оролцдог улс төрийн намыг бүртгэх үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх тараах эсэх асуудлыг хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр хараат бусаар шийдвэрлэх шаардлагын үүднээс гүйцэтгэх засаг, эрх мэдлийн байгууллагад бус харин Улсын дээд шүүхэд нийт шүүгчийн хуралдаанд харьяалуулсан гэж үздэг гэдэг дүгнэлтийг ҮХЦ дээр бас тавьсан байгаа юм л даа.

Тэгэхээр нэгдсэн холбоог бүртгэх агуулга маань энэ улс төрийн намын бүртгэл энэ 2 өдөр шөнө шиг бас ингээд зарчмын хувьд, агуулгын хувьд ялгаатай байна гэдэг тайлбарыг бас тавьсан байгаа юм. Гэхдээ бас гишүүд бас ярьж байна. Энэ эсвэл СЕХ ч юм уу ус бусад хуулийн этгээдээр бүртгэх энэ өөрөө Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25.8.8 дээр тодорхой зааж өгсөн байдаг юм байна лээ.

Дээд шүүхийн тайлбар нь ингэж оруулж өгсөн байна. Тэгэхээр итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд ч гэсэн байр сууриа илэрхийлэхдээ бол бас мэдээж Улсын Их Хурлаас баталсан хууль байна. Гэхдээ бас энэ мэргэжлийн нэгдсэн холбоо гэдэг бас л яг л мэргэжлийн холбоодууд нэгдээд бас дахиад л ТББ байгуулж байгаа хэлбэр.

Тэгэхээр энэ бүртгэл нь гүйцэтгэх бас байгууллага дээрээ явах нь бас зарчмын хувьд, агуулгын хувьд бас зөв байж байгаа. Тэгэхээр Үндсэн хуулийн энэ цэцийн дүгнэлтийг бас хүлээж авах нь бас итгэмжлэлийн төлөөлөгчийн хувьд бас зөв гэж үзэж байна аа. Тантай санал нэг байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүнд минут өгье.

Д.Ганбат: Ер нь Цэцэд хүндэтгэлтэй хандах Цэцийн шийдвэр гармагцаа биелэгддэг байх энэ асуудал маань ер нь ямар байгаа вэ. Энэ олонхыг хараад байхад нэг хэсэг нь биелүүлье гээд яваад байх шиг байх юм. Нэг хэсэг нь бол Цэцийн шийдвэр юу юм бараг хэзээ дуртай цагтаа нулимж болно ч гэсэн юм шиг юм яриад байх юм. Тэгээд энэ чинь хууль дээдэлдэг ийм улс оронд амьдарч байгаа бид нар. Хууль дээдлэх ёстой төрийн ажил хийх зарчим нь бол. Энэ байдал ямар байгаа юм.

Д.Цогтбаатар: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Өөрийнхөө хариулж болох эрх мэдлийн хүрээнд хариултаа өгөөд явъя.

Ганбат гишүүний асуултад яг өнөөдрийнхөө яг холбогдох асуудлын хүрээнд мөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн яг заагдсан үүргийнхээ хүрээнд хариулъя аа. Тэгэхээр өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гараад Монгол Улсын Дэгийн тухай хуулийн дагуу ХЗБХ-оор хүлээж авах талаар хэлэлцэж байгаа. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд бол Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасных нь дагуу тайлбарыг нь явуулсан.

Дунд суудлын хуралдаан бол 2026 оны 2 сард дунд суудлын хуралдаан болоод Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарч өнөөдөр итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд ХЗБХ-нд ийнхүү танилцуулж байна аа. Тэгээд ХЗБХ-ны гишүүд та бүхэн үүнийг хүлээж авах авахгүйгээ шийдээд цаашаа бид нар явна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр Үндсэн хуулийн олгогдсон эрхийнхээ хүрээнд та бүхэн шийдвэрлэж өгөхийг итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд хүсье ээ. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуултаа асуулаа, хариултаа авлаа. Надад нэг асуулт байна.

ҮХЦ тэгэхээр 2 адилхан хуулийн этгээдийг бүртгэхэд 2 өөр хандлага гаргаж байна шүү дээ. Мэргэжлийн холбоодыг бүртгэх нь буруу. Тэгсэн мөртөө адилхан хуулийн этгээд намыг болохоор бүртгэх нь зөв өө гээд. Тэгээд өгч байгаа тайлбар нь бол газар тэнгэр шиг 2 өөр ялгаатай асуудал учраас ач холбогдлын талаас нь гэсэн тайлбар өгч байна. Би зүгээр эрх зүйн хувьд энэ манай бас Байнгын хорооны гишүүд энийг яг бодоорой. Эрх зүйн хувьд энэ чинь зөв үү? Тийм категориор ялгаж болох юм уу? Одоо жишээлбэл Өмгөөлөгчдийн холбоо гэдэг чинь Монгол Улсын иргэн болгоны эрх чөлөөг хариуцаж байгаа байгууллага. Энэ утгаараа тэр намаас чинь ерөөсөө дутахгүй. Одоо жишээлбэл намтай харьцуулбал Өмгөөлөгчдийн холбоо бол арай жижиг юм л даа гэж ялгавар гаргах нь л дээ.

Тэгэхээр тэр бол тийм зөв шалгуур байх уу, эс үгүй бол энэн дээр ямар нэгэн онцолж ҮХЦ арай өөр нөгөө ач холбогдол талаас нь биш өөр тайлбар үндэслэл өгсөн үү?

О.Батнайрамдал: Цогтбаатар гишүүний асуултад хариульъя аа.

Тэгэхээр сая агуулгын хувьд ялгаатай байдал бол олон тайлбаруудынх нь нэг л хэсэг байгаа. Сая гишүүд асуусан учраас би яг тэр тайлбар хэллээ. Тэрнээс гадна бас олон тайлбарууд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдсан байгаа. Жишээ нь одоо ингэж байгаа юм. Улсын Дээд шүүх энэхүү бүртгэлд оролцох нь эрх зүйн онолын хувьд болон хууль зүйн чиг үүрэгтэй тохирохгүй төдийгүй шүүх эрх мэдлийн чиг үүрэгтэй зөрчилдөх үр дагавар 1 дүгээрт үүсэхээр байна гэсэн байгаа.

Хоёрдугаарт тухайлан сая жишээ өглөө. Хуурай замын тээврийн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоод бүртгүүлэх гээд. Гэтэл гишүүд нь гомдол гаргаад ингээд асуудал болоод шүүхдээ явах нь ээ. Тэгэхээр энэ буцаад шүүх дээр энэ гомдол ирэхэд хуулийн этгээдийн шүүхэд гомдол гаргах эрх нь хязгаарлагдах түүнчлэн шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах журмаар шийдвэрлэх шийдвэрийг хянуулах боломжийг хаах үр дагаварт хүрэхээр байгаа нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн холбогдох заалтад бас нийцэхгүй байна гэсэн олон төрлийн бас тайлбар дүгнэлтүүд бас байгаа гэдгийг нь хэлэх ёстой байх аа. Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан Улсын Дээд шүүхийн үндсэн чиг үүргийн агуулгатай бас нийцэхээргүй болсон байна гэсэн дүгнэлтийг бас энд хэлсэн байна.

Тэгэхээр Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт өөрөө бас бараг хориод хуудас нэлээн урт олон дүгнэлтүүд, олон шалтгаанууд, холбогдох үр дагавруудыг бол сая дурдсан. Тэгэхээр тэрэн дээр сая асуулттай хариулттай холбоотойгоор зүгээр улс төрийн намын бүртгэлтэй холбоотой тэр агуулга зүгээр гишүүдийн асуултад хариулт маягаар ганцаараа дурдагдчих шиг боллоо. Энэнээс гадна бас олон үр дагавартай холбоотой зөрчилдөж байгаа агуулгуудыг дурдсан байна аа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би дүгнэлтийг хүлээгээд авчихъя гэдэг зүйл байна. Ер нь зүгээр цаашдаа энэ дүгнэлтээс харахад улс төрийн намын бүртгэл ч гэсэн Улсын дээд шүүхэд байх нь зөв үү, үгүй юу гэдэг асуудал цаана нь яригдаж байгаа. Ер нь бол Улсын Дээд шүүхэд тодорхой ийм бүртгэлүүд байдаг тогтолцоонд юу вэ гэхээр эд хөрөнгийн эрхийн бүртгэл, иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, Улсын дээд шүүхийнх нь дэргэд байдаг институцүүд байдаг. Яах вэ Ром Германы, Герман энэ тэрд байна. Манайд бол Засгийн газар гүйцэтгэх эрх мэдэлтэй байгаа. Улс төрийн намыг салгаж аваад ингээд өгчхөж байгаа нь нэг талдаа харин улс төрийн намын энэ зохион байгуулалт, эрх зүйн байдал, тэдгээрийн нийт гишүүдийн эрхийг ч гэсэн зөрчиж байгаа үйл явдал байхыг үгүйсгэхгүй. Өөрөө өөрийнхөө бүртгэлийг дараа нь ямар байдлаар хэн хянах вэ гэдэг асуудал байгаа байхгүй юу.

Тийм учраас СЕХ энэ чиглэлийнхээ бүртгэлийг хийгээд энд гарсан шийдвэрийг Улсын Дээд Шүүх байдаг юм уу, ҮХЦ-ээрээ хянуулаад энэ улс төрийн нам түүнийг дагасан байгуулагдах, өөрчлөгдөх, татан буугдах байдаг юм уу энэ

харилцаагаа хуулийн хяналтад бас оруулаад явах нь ер нь зүгээр энэ Үндсэн хуулийн эрх зүй талаасаа зөв байх даа гэж би зүгээр хувьдаа боддог. Энэ зүйл бол ер нь зүгээр энд яригдаж байна аа. Шүүхийн тухай хуулийг боловсруулж байхад ч гэсэн энэ асуудал яригддаг.

Алтанхуяг гуай ч гэсэн мэдэж байгаа даа. Тэгэхдээ уламжлалд 1992 оноос хойш явж ирсэн уламжлал жишиг нь энэ юм гээд үлдээж байсан жишигтэй л юм байгаа юм. Сая Цогтбаатар дарга ч хэлж байна. Адилхан хуулийн этгээдийн бүртгэлийг ингэж үндэслэлээр явж болох уу үгүй юу? Тэгэхээр цаана нь бас үр дагаврууд энэ дээр үүснэ ээ. Энийгээ бид нар зайлшгүй энэ бас парламент тодорхой судалгаа шинжилгээ хийж энэ асуудлаа цэгцлэх ёстой. СЕХ-ныхоо эрх зүйн байдал бүх юмыг авч үзэх ёстой л гэж би зүгээр хувьдаа үзэж байгаа. Ер нь зүгээр тэр мэргэжлийн холбоодын асуудал гэвэл Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Нотариатын танхим, Нягтлан бодох бүртгэлийн институт, Хөрөнгийн үнэлгээчдийн холбоо ч гэдэг юм уу ийм байгууллагууд ингээд мэргэжлийн холбоо аль хэзээний байгуулагдчихсан. Ер нь ихэнх нь хуультай. Хуулиар л явж байж энэ асуудал цэгцэрдэг буюу яг албан ёсны бүртгэл энэний үр дагаврыг хамтаараа хариуцаж эсвэл хамтын дүрмээ тогтоодог ийм л зарчим байгаад байгаа. Яг нэгдсэн энэ холбоогоор явна гэдэг хэцүү. Ийм байхгүй гэвэл хуулийн этгээдүүд нь эдийн засгийн холбоо буюу ХАҮТ-ынх дээрээ яг чиглэл чиглэлийн танхимаа байгуулах ёстой. Бусдууд нь төрийн байгууллага буюу холбоо, сан гэдэг байдлаараа л явах нь зүйтэй байгаа юм аа. Тэгээд нэгдсэн 1 гээд буюу ийм тээвэр холбооны асуудлыг гаргаж ирээд энийг нь Улсын Дээд Шүүхээр хүлээн зөвшөөрүүлнэ гэдэг бол энэ боломжгүй асуудал байгаа. Энэ хуулийн төсөл бүүр анхнаасаа гарахдаа Засгийн газрын гишүүн нь бүүр мэргэжлийн холбоог зөвшөөрөхөөр байсан байхгүй юу.

Тэгээд явж явж энэ нь дийлэхгүй болохоор Улсын Дээд Шүүх ч гэсэн энэ нь бас буруутай явчихлаа. Тэгээд би бол дүгнэлтийг хүлээж аваад цаашдаа энэ Мэргэжлийн нэгдсэн холбооны хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг Эдийн засгийн байнгын хороо байдаг юм уу, ТББХ байдаг юм уу, ХЗБХ хамтраад дүгнэлт өгөөд энэ хуулийг яаж сайжруулах вэ гэдэг асуудлаа зөв болгох нь зүйтэй байх аа. Энэ бол зөвхөн бүртгэлийн асуудал биш. Одоо энийг ингээд УБЕГ-т бүртгүүл гээд өгсөн ч гэсэн дараа нь асуудал үүснэ.

Тухайн тэр этгээдүүд яг тэр салбарыг төлөөлж чадах уу, үгүй юу гэдэг чинь эргэлзээтэй байхгүй юу. Энэ мэргэжлийн холбоонд чинь бид нар төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх гээд байгаа юм. Шилжүүлж байгаа чиг үүрэгтэй нь хүний нөөцийг өгөх гээд байгаа юм. Шилжүүлж байгаа чиг үүрэгтэй нь төсвийн тодорхой хөрөнгийг өгөх гээд байгаа юм. Салбарын стандартыг сайжруулах, апдэйт хийх энэ асуудлыг яах гээд байгаа юм. Салбарын хууль тогтоомж захиргааны хэм хэмжээний акт дээр эд нараас санал авах гээд байгаа байхгүй юу. Яг бүрэн төлөвлөж чадаж байна уу гэдэг чинь бас нэг өөр асуудал.

Тэгэхээр энэ асуудлыг илүү их зөв болгож байж одоо энэ төрийн шийдвэр дээр мэргэжлийн оролцогчдын санал бодлыг сонсоно оо гээд байгаа тэр концепт чинь бүрэн хэрэгжих юм аа. Түүнээс биш цүнх барьсан, тамга барьсан 2, 3 хүмүүс салбарыг төлөөлөөд явж байгаа энэ жишгийг ер нь арилгах ёстой. Зөндөө жишгүүд бий. Жишээ нь Япон зөвхөн бол Засгийн газар нь хүлээн зөвшөөрөх шийдвэр гаргаж байж мэргэжлийн холбоог байгуулдаг.

Тэгэхээр ийм зүйлүүд байгаа. Тэгэхдээ би заавал яг ингэж байгаа юм биш. Энийг илүү их.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Би энэ Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлтийг бол дэмжиж байна. Мэргэжлийн нэгдсэн холбоо гээд ТББ, энэнийг Улсын дээд шүүх бүртгэнэ гэдэг нь буруу юм гэж. Тэгэхээр энийг дэмжиж байна. Би харин нэг юм жаахан дутуу ойлгочхов уу? Энэ Улс төрийн намыг бүртгэхтэй холбоотой Улсын дээд шүүхийн чиг үүрэгтэй агуулгын хувьд ялгаатай тухай ярьсан болохоос биш энэний зөв бурууг энэ дээр хөндөөгүй л гэж ойлгосон тийм ээ. Энэ тусдаа асуудал. Бид нар ярих ёстой асуудал. Яг энэ Цэцийн дүгнэлттэй хамаагүй.

Нэгдүгээрт бол би бас энэ олон жилийн явцад юу харж байгаа вэ гэхээр Улсын Дээд шүүхэд улс төрийн намыг бүртгэдэг бүртгэлгүй өгснийх буруу болжээ. Бид нар анхнаасаа энэ юу гэж явсан юм гэхээр энэ бол бүртгэлийн систем байх ёстой гэж явсан. Одоо бол зөвшөөрлийн систем болж хувирсан. Бараг дарга нь хэн байхыг заах шахуу болдог. Шүүхийнхэн заадаггүй юм гэхэд өөр газраас зааж өгдөг болсон. Тэгээд дүрэм журмаа зөрчсөн байна, тэгэхдээ бид нарт бас алдаа байгаа шүү зөвхөн Дээд шүүхэд байгаа биш. Тэр нь бид нар энэ намын тухай хуулийг их либерал болгомоор байна. Тэр Үндсэн хууль дээр заачхаад байгаа болдоггүй хэдэн зүйлийг л хориглосон заалттай. Тэгээд Ерөнхий хууль гаргаж өгмөөр байна. Ингэхгүй бол бараг анхан шат чинь ямар байх юм, дарга чинь хэн байх юм, бүтэц чинь ямар байх юм. Бид нар буцаад ерөөсөө коммунист намынхаа бүтцээс салахаа байлаа шүү дээ.

Тэгэхээр энд бид нарын Их Хурлын гишүүдийн, манай Их Хурлын институцийн бас алдаа байгаа шүү. Энийг хэдүүлээ даруйхан засахгүй бол болохгүй байна. Ер нь бол тэгээд харин нэг юмыг зохицуулах ёстой. Одоо сүүлдээ энэ өмнө нь байгуулагдсан манайд нэг ийм юу байна шүү дээ одоо хамгийн номер нэгд МАН, тэгээд АН гээд явдаг шүү дээ. Тэгээд энэ намуудын дарааллыг хүртэл шоддог систем рүүгээ орохгүй бол энэ нэрийг худалдаалдаг наймаалдаг ийм систем та нарт харагдаж байгаа биз дээ.

Эсвэл 3 дугаар байранд байгаа нам хэчнээн үнэ хүрчхэв. Та нар харж байгаа шүү дээ. Бид нар хараагүй юм шиг л суугаад байгаа байхгүй юу. Тэгээд ийм заваарсан юмнуудаасаа салахгүй Монголд улс төрийн намууд цэвэршихгүйгээр улс төрийн намууд зөв дүрэм журмаар хоорондоо өрсөлдөхгүйгээр энэ тогтолцоо бол улам муужирна. Ялангуяа парламентыгаа хамгаалъя гээд ярьж байгаа тохиолдолд бол энэ улс төрийн намуудыг зөв болгох ёстой. Тэр нь бүртгэлийн системийг нь буцааж сэргээх ёстой, зөвшөөрлийн системийг бид нар алга болгомоор байна аа.

Ингээд би бол Цогтбаатар даргын хэлж байгаатай, Сайнзориг гишүүн, Ганбат гишүүн бүгдээрээ бид нар нэг санал нэг юм яриад байна шүү дээ. Тэгэхдээ энэ энэнтэй холбоотой асуудал биш шүү дээ. Тэгээд тусдаа хэдүүлээ энийгээ өөрчилж сайжруулъя аа. Шүүхийн хууль дээр би анх ярьсан шүү дээ. Одоо салгах цаг нь болсон нь энэ Улсын дээд шүүх дээр буруу гэсэн. Тэгээд л жаахан уламжлалаа жаахан дээдэлдэг хүмүүс олон байсан учраас тэгээд дэмжигдээгүй. Янзалья тэгэх үү? Баярлалаа.

Д.Цогтбаатар: Би нэг 2 үг бас нэмээд хэлчихье гэж бодож байна.

Энэ дээр юу гишүүдийн хэлж байгаатай би санал нэг байна энэ өөрчлөхгүй бол болохгүй. Тэгээд хамгийн гол нь энэ ийм юм байх юм. Энэ хууль нь анх орж ирэхдээ Засгийн газраас өргөн барихдаа энэ бүртгэлийг нь Дээд шүүх дээр бүртгүүлэхээр оруулаагүй юм байна. Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг нь ажиллаж байгаад Дээд шүүх дээр бүртгүүлэхээр тавьчихсан юм байна. Нөгөө одоо яг асуудал нь намыг Дээд шүүх дээр бүртгэдэг учраас ажлын хэсэг тэгвэл ингэж болох нь байна гээд тийшээ явуулчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо яг эндээс өөрөөсөө ургаж гарч ирж байгаа асуудал яах аргагүй Дээд шүүх дээр тэр нам бүртгүүлээд байгаа энэ өнөөдрийн ярих асуудлын хүрээний юм биш ч гэсэн тойруу замаар энийг ярихаас өөр үггүй болчхож байгаа байхгүй юу. Адилхан бүртгэл яваад байгаа болохлоор тэгэнгүүт энэ дээр тэр бүртгэл чинь зөв үү буруу юу гэдэг асуудал өөрийн эрхгүй гараад ҮХЦ энэ дээрээ бас тайлбар өгсөн байна шүү дээ.

Тэгэхдээ би Үндсэн хуулийн цэцийн өгсөн тайлбарыг их эвтэйхэн дипломат аргаар энийгээ ч соль гэж бид нар захиалга өгсөн юм байна гэж би харлаа шүү. Яагаад гэвэл Үндсэн хуулийн цэцийн өгч байгаа тайлбар өөрөө энэ юутайгаа авцалдахгүй энэ ингээд яаж ч тайлбарлах гээд энэ чинь авцалдахгүй байна. Гэхдээ бид нараас асуусан асуулт энэ л учраас би энэндээ хариулж байна гээд.

Жишээлбэл ингэж байгаа байхгүй юу. Тэр зам тээврийн нэг ТББ-ын нэг маргаан байна шүү дээ. Энэ буцаад тэр шийдвэр нь шүүх дээрээ очихлоороо яах юм бэ гэж байна шүү дээ. Яг энэ логикоор намын маргаан бүүр ямар ч холбооноос илүү маргаан нам дээр бүүр их гарах байхгүй юу. Тэгээд шүүх дээрээ очихлоор яах юм? Яг л ийм байдал үүснэ шүү дээ, нэгт,

Хоёрт, нэг аягүй чухал юу шүүхийн яг өөрийнх нь энэ юу хариуцах асуудлын хүрээний асуудал биш байна гэсэн тайлбар өгсөн байгаа байхгүй юу. Тэгвэл яг тэр утгаараа намын тэр бүртгэл чинь яг шүүхийн шүүх бол шүүхээрээ л байх ёстой. Түүнээс аливаа юм бүртгэдэг байгууллага биш байгаа байхгүй юу. Тэр нь бүүр амин чухал ач холбогдолтой нам байсан ч лав шүүх биш. Нэгэнт энэ дээр л шүүх шүүхээрээ байх ёстой гэж байгаа бол ҮХЦ бид нарт өгч байгаа юу нь энэ дээр ч гэсэн шүүх шүүхээрээ байх ёстой шүү намын бүртгэлийн асуудал дээр гэдэг юу дохио өгч байна гэж би хүлээж авч байна.

Тэгээд энэ дээр зүгээр юу үнэхээр бид нар эргээд парламент дээрээ энийг харахгүй бол болохгүй юм байна аа. Яагаад гэвэл шүүх нэг том Үндсэн хуулийн цэцийн юун дээр ч яригдаагүй байгаа нэг зүйл энэ байна. Намыг бүртгэнэ гэдэг бол өөрийн эрхгүй шүүхийг улс төржүүлж байгаа юм. Намыг улс төрөөс ангид бүртгэнэ гэж байхгүй гэдгийг бид нар амьдрал дээрээ харцгааж байна. Тэр аль нам нь хэн нь байх ерөөсөө падгүй. Ерөөсөө систем нь өөрөө буруу байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэн дээр бол энийг бид нар Их Хурал дээр манай Байнгын хороо бол энийгээ эндээ яриад өөрөөр хэлбэл би лав бүлгийн даргатайгаа ч гэсэн өөрийнхөө шугамаар ярина. Энэ дараагийн юун дээр энэ намын бүртгэлийг Дээд шүүх дээр байдгийг бид нар өөрчлөхгүй бол болохгүй юм байна шүү гэдэг энэ саналыгаа бол Их Хурлынхаа түвшинд гаргаж яриад хууль санаачлах тал дээр ажиллах ёстой юм байна гэж бодогдож байна. Түүнээс бол Үндсэн хуулийн цэцийн энэ шийдвэрийг хүлээж авъя гэсэн ийм саналтай байна аа. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Мэргэжлийн нэгдсэн холбооны одоо ингээд санал хураалт явуулна. Санал хураалтдаа гишүүд бэлтгэе.

1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

46.7 хувиар санал дэмжигдлээ.

Отгонбаяр. Гишүүн горимын санал гаргая.

У.Отгонбаяр: Уучлаарай цагтаа амжиж дарах гэсэн хоцорчихлоо. Тэгээд энэ саналыг цуцалж өгнө үү гэж.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүн уншиж танилцуулсан байгаа. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Сүүлийн санал хураалт байгаа.

4.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг гишүүн танилцуулчих уу? Хэн танилцуулах уу? Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн танилцуулна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

12.16 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Сүүлийн жилүүдэд үе тэнгийн дээрэлхэлт нь тохиолдлын шинжтэй бус давтагддаг системийн шинжтэй үзэгдэл болоод даамжирч хүүхдийн эрх эрх чөлөөг ноцтой зөрчих нөхцөл байдал үүсэж байна аа. Тус асуудал нь зөвхөн боловсролын байгууллагын дотоод зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжгүй болж эрх зүйн зохицуулалтын уялдаа, хэрэгжилт, хяналт, хариуцлагын тогтолцооны хүрээнд цогцоор нь авч үзэх шаардлага бий болж байна аа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд хүний нэр төр, алдар хүнд, халдашгүй байдлыг хамгаалах, сурч боловсрох эрхийг баталгаажуулсан бөгөөд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах үүргийг мөн хуулиар хүлээсэн. Үүний дагуу Хүүхдийн эрхийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Боловсролын тухай хууль зэрэг хууль тогтоомжид хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийллээс хамгаалах, зөрчлийг таслан зогсоох, хариуцлага тооцох зохицуулалтууд тусгагдсан байдаг аа. Гэвч практикт үе тэнгийн дээрэлхэлтийг илт илрүүлэх, ангилан тодорхойлох эрх зүйн ойлголт шалгуур тодорхой бус эрүүгийн хариуцлагын зааг хэрэглээний практикт жигд бус боловсролын байгууллагын дотоод хяналт хариуцлагын механизм, үр нөлөө сул, холбогдох байгууллагуудын чиг үүргийн уялдаа хангалтгүй, цахим орчин дахь дээрэлхэлтийг зохицуулах эрх зүйн зохицуулалт хүрэлцээгүй байгаа нь илэрч байна аа.

Энэ нь дээрх хууль тогтоомжуудын зохицуулалтын давхардал, хийдэл, хэрэгжүүлэлтийн зөрүү, хяналт, хариуцлагын тодорхой бус байдал байгааг харуулж байгаа бөгөөд ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд уг асуудлыг эрх зүйн орчны түвшинд хянан шалгаж, үнэлж, бодлогын шийдэл боловсруулах ажлын хэсэг байгуулж ажиллах шаардлага үүссэн байна аа.

Энэхүү ажлын хэсгийг байгуулах нь үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хийдэл, зөрчлийг илрүүлэх, холбогдох хуулиудын уялдаа нийцлийг хангах, зөрчлийн болон эрүүгийн хариуцлагын зохистой зааг, хэрэглээг тодорхой болгох, боловсролын байгууллагын хяналт, хариуцлагын механизмыг эрх зүйн хувьд бэхжүүлэх хүүхэд хамгааллын чиглэлээр салбар хоорондын зохицуулалтыг сайжруулах зэрэг ХЗБХ-ны үндсэн чиг үүрэгт хамаарах бодлогын ач холбогдолтой.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны үр дүнд үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтын иж бүрэн дүн шинжилгээ гаргах. Хууль тогтоомж, хоорондын зөрчил, давхардал, хийдлийг арилгах, санал боловсруулах. Зөрчлийн болон эрүүгийн хариуцлагын хэрэглээний нэгдмэл ойлголт чиглэл тодорхой болох, Боловсролын байгууллагын хариуцлага, дотоод журам, хяналтын тогтолцоог сайжруулах эрх зүйн шийдэл боловсруулах, цаашид холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн суурь санал бэлтгэгдэнэ гэж үзэж байгаа юм аа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Би энд нөгөө төслийг санаачилж оруулахдаа Байнгын хорооныхоо гишүүдтэй ярилцаад энийг ингээд оруулж ирье гээд та бүгддээ ярьсан байгаа.

Би тогтоолынхоо төслийг уншаад танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол

2026 оны дугаар сарын дугаар өдөр, дугаар Улаанбаатар хот ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалтыг үндэслэн ХЗБХ-оос тогтоох нь:

1.Хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах хүрээнд үе тэнгийн дээрэлхэлтийн шалтгаан нөхцөл, илрэлийн хэлбэр, хор уршгийг тодорхойлон үнэлж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай гээд.

Би Одонтуяа гишүүнтэй санал солилцоод энэ ажлын хэсгийг та даргалаад өгөөч гэдэг хүсэлт гаргасан байгаа юм.

Тэгээд гишүүд бол бас өөрсдийнхөө саналыг хэлсэн байгаа. Би тэгээд санал хэлсэн гишүүдийг энд оруулаад бичсэн байгаа.

Ажлын хэсгийн гишүүд Даваагийн Цогтбаатар Улсын Их Хурлын гишүүн.

Жудгийн Баярмаа Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүн, Баярбаатар Улсын Их Хурлын гишүүн, Соронзонболд Улсын Их Хурлын гишүүн, Д.Ганбат Улсын Их Хурлын гишүүн, Баасанжаргал Улсын Их Хурлын гишүүн, Г.Уянгахишиг гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр Улсын Их Хурлын гишүүд. Тэгээд гишүүд бас нэмэгдэж болно. Зүгээр яах вэ энэ дээр бол яг бид нар цэвэр хууль зүйн юунаасаа хийе гээд. Би тэгээд та бүгдэд нэмж мэдээлэл өгөхөд төрийн бус байгууллагуудтай уулзаад эхэлсэн. Багш нарын зөвлөл гээд бүхэл бүтэн том байгууллага байлаа. Тэд нартай уулзсан.

Та нар энэ дээр ингээд анхаараад дэмжээд өгвөл бид нар маш их баярлах болно оо гээд тэгж байна лээ.

Өчигдөр Юнисефтэй очиж уулзсан. Юнисеф бол бид нар дэмжээд өгье. Олон улсын түвшинд энэ боловсрогдсон байгаа туршлага юмнуудыг бид нар нэгтгээд энэ чинь оролцоод өгсөн юм гэсэн байгаа юм. Болно болно тэгээд ер нь хэдүүлээ хэлэлцээд л явъя энэ дээр. Тэгвэл энэнтэй холбогдуулаад санал хэлэх гишүүд нэрсээ өгөх үү?

Асуулт асууж санал хэлэхээ нэгтгэчихье.

Ингээд Ганбат гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Үе тэнгийн дээрэлхэлтийн асуудал бол хууль зүйн талаас өөр ойлголт л доо. Заавал 2 түүнээс дээш хүүхдүүд бусад хүүхдийнхээ эсрэг давтамжтай ийм үйл ажиллагаанууд байгаа. Тэгээд яг хуульчлах гэдэг юм уу, эрүүгийн хариуцлага, хууль зүйн талаасаа хариуцлагын асуудлыг маш ньуанстай явахгүй бол хүүхдүүдийг бас хэт их эрүүжүүлэх юу гэдэг юм олноор нь ч гэдэг юм уу ийм зүйл рүү оруулчихдаг ийм талтай байдаг. Тийм учраас энэ Эрүүгийн хууль болон Зөрчлийн хууль руу оруулахдаа маш болгоомжтой оруулахгүй бол угаасаа үйлдэгдэх буюу хэр хэлбэр нь бүлэг байдлаар үйлдэгддэг ийм зүйл байгаа.

Тэгэхээр энийг бас нэг анхаараасай гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт яах вэ зүгээр энэ үе тэнгийн дээрэлхэлтийн зан үйлийг засах сургалтын асуудлыг хийнэ гэж байгаа боловч хэн нь хариуцаж хийх нь ямар хөтөлбөрийн дагуу хийх дээрээс нь төсөв мөнгө зардал нь яах энэ төлбөртэй төлбөргүй байх юм уу? Ээж ааваас нь гаргуулах уу үгүй юу гээд маш олон зүйлүүд нь зүгээр

Хүүхдийн эрхийн тухай хууль дээр ерөнхий байдлаар бичээстэй болоод энэ хэрэгжихгүй байгаа.

Тэгэхээр ийм зүйлүүдийг бас зайлшгүй бас анхаарч явах ёстой юм. Тэгээд яах вэ зүгээр бие даасан хуультай байх уу үгүй юу? Олон жижиг хуулиуд дээр яах вэ хууль хэрэглээний явцад бас жоохон хэцүү байдаг. Уг нь ээж аав нарт бас нэг хуулийг хараад ч юм уу, сурган хүмүүжүүлэгчид нэг хуулийг хараад явахад их амар.

Хүүхдийн эрхийн тухай хууль дээр яах вэ нэг бүлэг оруулж болох боловч бас яах вэ зүгээр би бол нэг 20-оод зүйлтэй хууль боловсруулчихсан байдаг. Надаас бас энэ хуулийн төслийг бас бас авч болно шүү гэж би хэлмээр байна. Тэгээд ер нь зүгээр яах вэ илүү их зүгээр зохион байгуулалтын асуудал талдаа байгаа шүү. Эрүүгийн гэдэг юм уу хууль зүйн хариуцлагын хувьд л бол байгаа ерөнхийдөө байгаа. Тэгэхдээ энийг тодруулж өгөх зайлшгүй шаардлага байгаа. Гол нь бид хэд нэг их баахан одоо зохицуулалтууд хийчхээд энэ дээрээ төсөв тавьдаггүй, зохион байгуулалтыг нь хийе гэхийг нь ерөөсөө хариуцуулж, эзэнжүүлж чадаагүй, агуулга, хөтөлбөр нь юу байх вэ гэдэг зүйлийг шийдээгүй байгаад л гол асуудал байгаа.

Тэгэхээр магадгүй энийг суурин газрууд ч байдаг юм уу тодорхой эсвэл онлайнгаар ч байдаг юм уу, заавал ээж, аавтай нь биечлэн сургалтад сууж байж л илүү үр дүнтэй байх тал руугаа ордог юм байна лээ ер нь зүгээр.

Тэгэхээр энэ зүйлүүд рүү бас анхаараад бас энэ цахим орчин дахь асуудлыг бас жоохон уялдаатай аваад үзэж болно оо гэж үзэж байгаа юм. Тэгэхээр хэдэн хүн болчхов уу? Дарга. Би яах вэ зүгээр ороод эсвэл энэ дээр нь хууль эрх зүйн талаас нь бас оролцоод явж болж байна. Яах вэ зүгээр тэрийг бас харж байгаад тоо нь бас олдоогүй бол яах вэ бас орж болж байна шүү л гэж л хэлье.

Д.Цогтбаатар: Яг өөрийн чинь ярьж байгаа юутай би санал нэг байна. Тэгэхээр энэ ажлын хэсэг би хууль нь байгаад байгаа асуудал ерөөсөө хуулийн хэрэгжилт дээрээ тэрэнд хандах хандлага дээрээ зарим юман дээр үл тоомсорлох асуудал.

Тэгээд тэр нь багш нарын асуудал биш. Багш нар хөөрхий сургууль дээрээ бүгдээрээ юмаа хийе гэж бодож байгаа боловч яг амьдрал дээрээ юу байгаад байна гэхлээр аягүй олон эцэг эхчүүд сургууль дээр болж байгаа асуудал багш нарын асуудал гээд. Гэтэл хүүхдийн зан авиртай төлөвшчихсэн зан авиртай холбоотой асуудал бол нээрээ л эцэг эхчүүд өөрсдөө оролцохгүй бол энэ жишээлбэл шийдэхэд маш хэцүү. Гэх мэт ингээд өөрөөр хэлбэл хуулийн хэрэгжилт талаасаа л илүү их юу гаргая гээд. Тийм учраас нөгөө тогтоолын төсөл боловсруулъя гээд тэгээд хууль хэрэгжүүлэх байгууллагуудад нэмэлт рекомендац зөвлөгөө өгөх ийм талаас нь бодож байгаа юм.

Нарантуяа гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Энэ ажлын хэсэг байгуулах тухай надад энэ мэдээ би өнөөдөр л энийг анх удаа сонсож байна. Тэгээд би ажлын хэсэгт орох хүсэлтэй байна. Яагаад гэвэл энэ илүү яг нөгөө амьдрал дээр практикт өөрт нь тохиолдсон тохиолддог ийм эцэг эхчүүд энд оролцоод явах юм илүү их бас бодитоор хэмжих боломжтой ийм ажлын хэсэг болох болов уу гэж бодож байна.

Нөгөө талаар ер нь бол энэ одоо үе тэнгийн дээрэлхэлт гэдэг чинь хүүхдүүд ерөөсөө л томчуудаас сурч байгаа зүйл шүү дээ. Эд нар бие биеийгээ дээрэлхдэг учраас эд нар бие биеийгээ бүүлийддэг учраас бид нар ч гэсэн адилхан болно гэсэн тэр байдлыг томчуудаас суралцаж байгаа байхгүй юу. Энэ утгаараа Улсын Их Хуралд жишээлбэл ард нь бүхэл бүтэн том баялгийн бүлэглэл байдаг. Эм Си Эсийн төлөөллийн гишүүд. Төрийн албан хаагчдаа ингээд олон нийтийн өмнө сэтгүүлчдийн өмнө боож унагаагаад л, зодоод л чи миний Их Хурал дээр ингэж ярихгүй шүү гээд л ингээд аашилж байгаа чинь өөрөөр хэлбэл нөгөө талдаа хүүхдүүдэд цагдаа аавтай учраас би энийг дээрэлхэж болно гэдэг энэ үлгэр дуурайлыг өгч байгаа байхгүй юу.

Тэгэхээр энд бас ажлын хэсгийн гишүүдээ бас нэлээн ул суурьтай бас юу тодруулаасай гэж хүсэж байна. Нөгөө талаараа одоо үе тэнгийн дээрэлхэлтийг арилгах асуудал бол зөвхөн хуулийн, хуульд одоо жишээлбэл бид нар ингээд л хэчнээн сайхан ингээд л хууль цагаан дээр хараад биччихэж болно. Гэтэл хэрэгжилт байхгүй. Яг нөгөө ёс зүйн хууль шигээ өөрөөр хэлбэл алагчилдаг. Одоо ингээд л ёс зүйг оруулж ирэх гэж байна. Ингээд л ёс зүй гэхээрээ бөөнөөрөө нийлж байгаад л Нара хамгийн балиар гэдэг гээд л шахаад л. Гэтэл өөрсдийнх нь далд бузар булай хулгай зэлгий бүх юм нь байсаар байхад тэрэн дээр хэзээ ч цагаан дээр хараар биччихсэн хууль нь хэрэгжээгүйн адил, яг энэн шиг ийм хууль болчихвол зүгээр л хууль төдийгөөр дуусвал энэ бол үр дүнгээ нийгэмд өгөхгүй. Цааш цаашид үе тэнгийнхний дээрэлхэлт илүү том асуудал болоод явна.

Нөгөө талаар нэг зүйлийг маш сайн анхаарах хэрэгтэй.

Одоо жишээлбэл Ерөнхийлөгчийн зөвлөх гээд л баахан залуучууд ингээд байна. Ер нь залуу хүн мөртөө их тийм тийм коммунист үзэл санаатай юмнууд яриад байдаг. Үе тэнгийнхнийг бүртгэлжүүлээд хувийн хэрэг дээр нь бичээд ирээдүйд гадаад руу зорчих эрхийг нь хасах, их дээд сургуульд орох эсэхийг эрхийг нь хасах энэ тэр гээд ингээд бүүр ингээд хүүхдийг ингээд багаас нь ингээд яллах гээд байдаг. Гэтэл өнгөрсөн жил би жишээлбэл 5 дугаар ангийнхаа хүүхдийн үе тэнгийнхний дээрэлхэлтийн тухай асуудлыг бас шүгэл үлээж байсан.

Гэтэл хүүхдүүд гэдэг чинь өөрсдөө алддаг. Дараа нь бие биеийгээ ойлгодог, уучилдаг, эргээд найзууд болчихдог. Энэ жил жишээлбэл өнгөрсөн жил зодолдож байсан 2 чинь өнөө жил маш сайн найзууд болчихсон явж байгаа байхгүй юу. Тэгэхээр тэрэн дээр нь жишээлбэл тэр хүүхдийг энэ хүүхэд бүүлийдэгч гээд л баахан хар тамга дараад л тэгээд л тэр хүүхэд энэ жил энэ жил өнгөрсөн жилийнхээ юмыг мартсан байж байсан чинь томчууд бид нар өөдөөс нь баахан хувийн хэрэг дээр бүртгэл үүсгээд л, хар тамга дараад л ирээдүйд нөгөө хүүхэд чинь ажил амьдралаа хийх.

Д.Цогтбаатар: Нэг минут нэмж өгье Нараа гишүүнд.

М.Нарантуяа-Нар: Гэтэл энэ бүх юм нь аль хэдийн хар тамга дарчихсан байвал энэ хүүхдүүдийн ирээдүйд цаашлаад алдаагаа засаад хүн болгон алдсаар байж байгаад л хүн болж байгаа шүү дээ. Ер нь тийм биз дээ. Тэгэхээр ийм эрхэд бас халдах ийм хуулийн зүйл заалтын тухайд бол ерөөсөө энэ ажлын хэсгийн гишүүд битгий яриасай гэж бодож байна аа.

Тэгээд ажлын хэсэгт би орно шүү.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Их зөв зүйтэй ажлын хэсэг байгуулах гэж байгаа юм байна. Тийм дэмжиж байна. Тэгээд ерөөсөө энэ үе тэнгийн дээрэлхэлт бол нийгмийн тусгал байгаа байх л даа. Монголын нийгэм ямар байна вэ гэдэг тэрний тусгал л ингээд илэрч байна.

Энэ одоо хэр хэмжээнээсээ хэтэрчээ. Улсын Их Хурал дээр энэ талаар ажлын хэсэг байгуулах нь зөв өө. Гэхдээ энийгээ жоохон ихэсгээд энэ чинь томчуулын л толь шүү дээ тийм ээ. Тийм хүүхэд гэдэг бол. Тэгэхээрээ ганц нэг бичлэг энэ тэрийг харж байхад бол юу юм байна лээ шүү дээ. Тэр бүүр 2 настай, 3 настай хүүхдүүдийн тэр цэцэрлэгийн СӨБ-ын албан хаагчид нь харьцаж байгаа харьцааг нь харахад бол ганц нэг бичлэгтэй газар л мэдэгдээд байгаа юм л даа. Тэнд чинь тэгээд суулгачихсан, сандал дээр суулгаад нөгөөдхийг нь скочидчихсон, тэгээд зодож нүдэж байгаа энэ тэрийг нь харахад бол ер нь Монголын нийгэм юу болж байгаа юм бэ? Ирээдүй бол явцдаа яаж яваад байгаа юм бэ? Өнөөдрийн байгаа байдлаас болоод л ерөөсөө 30 хувь нь ядруултайгаа л, ихэнх нь эх эцгийн аль нэг нь гадаадад ажиллаж байна. Тэгээд өвөө, эмээ дээрээ орхиж байна. Хүүхдүүд бол тэр болгон эх эцгийн хайр халамжид өсөж чадахгүй байна шүү дээ. Тэгээд ямар ч байсан нэг цэцэрлэгт үнэ төлбөргүй явуулж байгаа нэртэй. Тэгээд болсон болоогүй хоол ундтай ийм байдалтай байна. Тэгээд нөгөө авах ёстой шим тэжээлээ ч авч чаддаггүй. Тэгэхээр энэ дээр бол тэр юуг оруулчихвал яасан юм бэ? Нэмээд тэр СӨБ-ын хүүхдүүдтэй харьцаж байгаа орчин нь ямар байгаа юм тийм ээ? Тэндээс насанд хүрэгчид яаж харьцдаг юм? Уул нь тэнд тийм пидофилүүд ажиллаж байх ёсгүй л дээ. Тэр мэрийг нь тогтоодог, барьдаг. Тэгээд тэрүүгээрээ үлгэр дуурайлал үзүүлдэг ийм гажиг хүмүүс тэнд орчихсон юм уу, яачихсан юм. Тэгээд бодвол цалин пүнлүү нь ч хүрдэггүй байх, тийм шаардлагатай тэр мэргэшсэн албан хаагчид ажилчид нь олддог ч үгүй байх.

Энэ багш нарын тоо, сургуулийн өмнөх боловсролын багш нарын цалин маш хүнд байдалтай байгаа шүү дээ. Тэгээд энэ энэ талаар нэгмөсөн тийм дүгнэлт байгуулаад санал, дүгнэлт гаргаад явбал яасан юм бэ? Ганцхан үе тэнгийн дээрэлхэлтийг л орхичхож байна. Тэрний эх үүсвэр нь хаанаас байдаг юм гэдгийг бас бид нар энэ дүгнэлтдээ оруулж яривал яасан юм бэ гэсэн ийм санал байна.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Баярлалаа. Энэ оръё гэсэн гишүүдийг бол бүгдийг нь ингээд оруулах нь зөв байх. Ганбат гишүүн ээ харин энэ нөгөө үе тэнгийн дээрэлхэлт яг эрх зүйн хувьд 2 тусдаа асуудал болчих гээд байна.

Тэгэхээр энд нөгөө үе тэнгийнхээ тулсан асуудлаа гэхдээ таны ярьж байгаа асуудал нээрээ зөв шүү. Энэ дээр бас бид нар ер нь анхаарч ажиллах ёстой. Энэ чинь нөгөө багш хүүхдийн хоорондын харилцаа болохлоор энийг ингээд холих юм бол аягүй өргөн хүрээтэй болох гээд байна. Тэгэхээр эхлээд хэдүүлээ энийгээ явуулаадахъя. Харин энэ дээр би зүгээр та бүгддээ мэдэгдэхэд сая би Монтенегрод болсон олон улсын хуралд ороод яахад үнэхээр тэр сэтгэл зүйд барууныхан бол аягүй нарийн юмнуудаа судалж байна. Тэр Монтенегрогийн профессор яг орж ирээд сургуульд хүүхдүүдийг яаж радикализац болдог юм бэ гэдгийг зүгээр өөрөө жижигхэн ийм туршилтын тоглоом хүүхдүүдээр тоглуулчхаж байгаа байхгүй юу.

Тэгээд тэрэнд ахмад оролцож байгаа хүмүүс оролцож байгаа юм. Тэгээд бүгдээрээ тоглож байгаад бүгдээрээ тоглож байна гээд л тоглож байсан чинь дараа нь та нар энийг энэ өнцгөөс хар даа гэхэд яг өөр өнцгөөр хүн яаж санаандгүй өөрөө мэдэхгүйгээр тэр дээрэлхэлт рүү тэр радикализац руу орж байгааг та нар бод доо. Хүүхдүүдийн хажуугаар ахмад тэнд эцэг эхчүүд байж байсан өөрсдөө тэрэнд орчихсон явж байгаа шүү дээ. Тэгээд яг тэр ингээд өнцгөөс би тэр Монтенегро эд нарынхантай холбогдуулж өгөөд энэ дээр энэ хурлууд хийгээд би эндээс юу олж харсан гэхээр асуудал байгаагаа мэдэж байгаа боловч яг тэрэн дээрээ онилж төрийн энэ байгууллага ингээд нарийвчилсан ерөөсөө ажиллаагүй юм байна лээ. Тэгэхээр энийг ингэж ажиллаж өгөөд рекомендац нэг цогц юм гаргаад өгчих юм бол асуудлыг 100 хувь шийдэхгүй гэхэд энэ аягүй том дэм болж өгнө. Бид нар тэгэхээр тэр өнцгөөсөө л ажиллаад үзье гэж байгаа юм. Тэгвэл би шинэчилсэн юугаа нэг уншаадахъя тэгэх үү? Ажлын хэсгийн ахлагч Одонтуяа гишүүн, дэд ахлагчаар Сайнзориг гишүүн, гишүүд нь Даваагийн Цогтбаатар, Баярмаа гишүүн, Баярбаатар гишүүн, Ганбат гишүүн Нарантуяа-Нара гишүүн, Уянгахишиг гишүүн гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр баталчих уу тэгвэл. Тэгье.

Тэгвэл гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Саяын уншиж танилцуулсан төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтдаа бэлдье эхлээд.

Бэлтгэсэн бол санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө.

Гишүүддээ идэвхтэй хуралдаандаа оролцсонд талархал илэрхийлье ээ.

12.35 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА